

## Улаанбаатар Цэвэр Агаар Нэмэлт Санхүүжилтийн Төсөл

Гэр хорооллын зорилтот бүсийн айл өрхийг “дулаан хуримтлуурт” цахилгаан халаагуураар хангахад зориулсан тооллого судалгааг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний HSTS-01 тоот ажил

### Ажлын удирдамж

#### 1. Удиртгал

МУЗГазар Дэлхийн банкнаас “Улаанбаатар Цэвэр агаар төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг хүссэн. Одоо хэрэгжиж байгаа “Улаанбаатар Цэвэр Агаар” төсөл нь А, Б, В гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй бөгөөд нэмэлт санхүүжилтийн хүрээнд шинээр “Бүрэлдэхүүн Д” нэмэгдэж байна. “Бүрэлдэхүүн Д”-нь зорилтот бүсийн гэр хорооллын айл өрхийн хатуу түлшээр ажилладаг зуухыг “дулаан хуримтлуурт” цахилгаан халаалтын хэрэгсэл буюу шөнийн дулаан хуримтлуур (ШДХ)-аар солиход чиглэгдэх ба энэ нь агаарын бохирдлыг бууруулах богино хугацааны арга хэмжээний нэг болох юм. Одоогоор төслийн бэлтгэл ажлууд хийгдэж байна.

Нэмэлт Санхүүжилтийн Төсөл (НСТ)-ийн хүрээнд 4 квт-ийн цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдсэн байршлуудаас 8000 айлыг сонгон авч ШДХ ханган нийлүүлж, суурилуулахаар төлөвлөж байна.

Ханган нийлүүлсэн бүтээгдэхүүн нь айл өрхийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан байхын тулд айл өрхийн дунд тооллого, судалгаа хийх нь нэн чухал шаардлагатай байгаа юм.

#### 2. Зорилго

Энэхүү Зөвлөх үйлчилгээний зорилго нь (i) Улаанбаатар Цэвэр Агаар Нэмэлт Санхүүжилтийн Төсөл (УБЦАНСТ)-ийн үр шимийг хүртэх 8000 айл өрхийг олж тогтоох (ii) эдгээр айл өрхийн хэрэгцээнд тохирсон ШДХ-ийг ханган нийлүүлэх/суурилуулах гэрээний тендерийн баримт бичгийг боловсруулахад шаардагдах тоон мэдээллийг гаргахад Захиалагчид дэмжлэг үзүүлэхэд оршино. Эдгээр ШДХ-ийг худалдан авах боломжтой 8000 айл өрхийг тодорхойлохын тулд Зөвлөх баг нь олон айл өрхөөр явж судалгааны ажлыг гүйцэтгэнэ. Төсөлд хамрагдах хүсэлтэй, техникийн шаардлага хангасан айл өрхийн тоо 8000 хүрмэгц зөвлөх баг тооллого, судалгааны ажлыг зогсооно.

#### 3. Ажлын хамрах хүрээ

Улаанбаатар Цэвэр Агаар Төслийн удирдах нэгж (ТУН) нь судалгаанд хамрагдах байршлыг Эрчим хүчний яам (ЭХЯ) болон Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК (УБЦТС) -тэй хамтран тодорхойлно.

Зөвлөхийн гүйцэтгэх тооллого, судалгааны ажил нь дараах даалгавраас бүрдэх ба үүгээр хязгаарлагдахгүй.

**Даалгавар 1:** Урьдчилан бэлтгэсэн шалгах хуудас болон асуулгыг судалж үзсэний дараа шаардлагатай гэж үзвэл энэхүү тооллого судалгаанд тохиромжтой байдлаар өөрчлөлт нэмэлтийг хийх;

**Даалгавар 2:** Цахилгааны нэг дэд өртөөнөөс холбогдсон байдлаар<sup>1</sup> нь айл өрхийг бүлэглэсний дараа айл өрх бүрээр орж ШДХ авахад бэлэн болохоо илэрхийлсэн 8000 айл өрхийг олж тогтооно. .

**Даалгавар 3:** Сонирхлоо илэрхийлсэн айл өрхүүд нь техникийн шалгуур хангаж байгаа эсэхийг шалган нягтлах ба техникийн шалгуурт тэнцсэн айл өрхүүд эцсийн дүгнэлтээр сонгогдоно. Сонгогдсон айл өрх бүрээс шалгах хуудас, асуулгын дагуу тооллого судалгааг авна. Техникийн нөхцөл, судалгааны үр дүн зэрэгт үндэслэн 8000 айл тус бүрт тохирох ШДХ-ийн өгөгдлийг зөвлөмжилнө. (тоо хэмжээ, хүчин чадал гэх мэт). Техникийн шалгуур ханган, ШДХ худалдан авахаа илэрхийлсэн айл өрх бүртэй ТУН-ийн нэрийн өмнөөс урьдчилсан тохиролцооны хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулна.

**Даалгавар 4:** Тооллого судалгааны үр дүнд суурилсан дэлгэрэнгүй тайланг бэлтгэх ба энэхүү тайлан нь техникийн болон нийгмийн гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Тайланг төсөлд хамрагдах айл өрхтэй байгуулсан урьдчилсан тохиролцооны хэлэлцээрийн хамт ТУН-д хүлээлгэн өгнө. Тайлан дахь багц мэдээлэл нь УБЦАНТ-ийн хүрээнд зарлагдах ХАА-ны суурь мэдээлэл болно.

Зөвлөх баг ТУН болон ЭХЯ-тай хамтран ажиллана. Зөвлөх баг нь айл өрх бүр нь техникийн шалгуур хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгөх дүгнэлт өгөхдөө УБЦТС ТӨХК-тай хамтран ажиллана. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа Зөвлөх баг нь ШДХ-т тавигдах техникийн шаардлага стандартыг боловсруулж, айл өрхийн түвшинд туршилт хийж байгаа гүйцэтгэгчтэй уялдаа холбоотой хамтран ажиллана. Даалгавар тус бүрийн ажлын даалгаврыг доор нарийвчлан тайлбарлав. Үүнд:

### ***Даалгавар 1: Судалгааны асуулгыг хянах, айл өрхөд түргэвчилсэн шүүлт хийх***

Судалгааны асуулгыг энэхүү ажлын даалгаварт хавсаргасан ба Зөвлөх баг нь тооллого, судалгааг гүйцэтгэх өөрсдийн арга зүйд үндэслэн, асуулгыг өөрчилж засварлаж болно. Асуулга нь төслийн хэрэгжилтийн үед болон хяналт шинжилгээнд ашиглагдах мэдээллийн сан болно.

Цаг хэмнэх үүднээс Зөвлөх баг айл өрхүүдэд дараах шалгуураар эхний шүүлтийг хийнэ.

- Шаардлага хангасан байр сууцны төрөл: (а) жижиг, дунд хэмжээтэй гэр сууц; (б) 2-оос илүүгүй өрөөтэй, 45м<sup>2</sup>-аас ихгүй талбайтай байшин сууц
- Одоо ашиглаж байгаа халаалтын хэрэгсэл нь уламжлалт зуух байх
- Хэрэв цахилгааны нэг тоолуурын дор хэд хэдэн хэрэглэгч байгаа тохиолдолд зөвхөн УБЦТС-д бүртгэлтэй хэрэглэгч хөтөлбөрт хамрагдах эрхтэй

Эхний шүүлтээр үлдсэн айл өрхүүдийг дараагийн шатны шалгуурт хамруулна. Шалгуурт доорх асуудлууд багтана:

- (1) Сууцны төрөл, хэмжээ, нөхцөл: Байшин болон гэр сууцны төрөл, хэмжээ, нөхцөл болон шинж чанарууд, тухайлбал гэр, байшин сууцны дулаалгын чанар цонх, хаалга, гэрийн бүрээсийн давхар зэргийг тодорхойлох
- (2) Айл өрхийн нийгэм эдийн засгийн болон хүн ам зүйн судалгаа, шинж чанар

---

<sup>1</sup> УБЦТС ТӨХК-ний мэдээлснээр нэг дэд өртөөнөөс 80-100 айл холбогддог ба 6 айлын тоолуур нэг хайрцагт байхаар багцалсан байдаг.

- (3) Айл өрхийн орлого зарлагын мэдээлэл
- (4) Хэрэглэдэг цахилгаан хэрэгслүүд: плитка, халаагуур, хөргөгч, ТВ, индүү гэх мэт
- (5) Цахилгааны хэрэглээ болон зардал: халаалтын улирал дахь сарын цахилгааны хэрэглээ (квт/ц) болон зардал (төг) хэд болох
- (6) Нүүрсний хэрэглээ: Нүүрсний төрөл, тоо хэмжээ (тонн/халаалтын улирал)
- (7) Халаалтын зардал: Нүүрс модонд хэдийг зарцуулдаг (Төг/халаалтын улирал)
- (8) Айл өрхийн хөтөлбөрт хамрагдах сонирхол

**Даалгавар 2: Айл өрх болгоноор явж тооллого судалгааг гүйцэтгэж төсөлд хамрагдах боломжтой 8000 айл өрхийг тодорхойлно**

Судалгааны зорилго нь НСТ-ийн хүрээнд сонгогдсон байршил дахь 8000 айл өрхөд ханган нийлүүлэх ШДХ цахилгаан халаагуурын тоо хэмжээ, хүчин чадал, техникийн тодорхойлолтыг боловсруулахад оршино. Зөвлөх баг айл өрх болгоноор явж, шаардлага хангасан өрхийг сонгохын өмнө тусгай маягт (схемчилсэн) бэлтгэх шаардлагатай. Энэхүү маягтад оруулах мэдээлэл нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд: цахилгааны тоолуур эзэмшигчийн овог нэр, хэрэглэгчийн дугаар, сууцны төрөл, сууцны хэмжээ, өрөөний тоо, халаалтын төхөөрөмж байрлах байршил, нэг хашаанд цахилгаанаа хувааж хэрэглэдэг айлын тоо, дэд станцын дугаар, холболтын схем, автомат (ampere breaker)-ын хүчин чадал, кабелийн хүчин чадал болон техникийн бусад нөхцөл зэрэг багтана<sup>2</sup>. Маягтын дагуу бөглөсөн мэдээлэл, судалгааны асуулга зэрэг нь эцсийн тайлангийн хавсралт болно. Зөвлөх баг шаардлагатай тохиолдолд багаар ярилцлага хийж болно.

**Даалгавар 3: Айл өрхтэй урьдчилсан тохиролцооны хэлэлцээр**

Дээр дурдсанчлан, төсөлд хамрагдахаар сонгогдсон 8000 айл өрхийн мэдээлэл дээр үндэслэн гаргасан ШДХ-ийн тоо хэмжээ, хүчин чадал нь НСТ-ийн хүрээнд зарлагдах ханган нийлүүлэлтийн гэрээний үндсэн өгөгдөл болно. Иймд сонгогдсон айл өрхтэй байгуулах урьдчилсан тохиролцооны хэлэлцээр (судалгааны үед албан бус байна)-ийг ТУН-ийн нэрийн өмнөөс байгуулах ажлыг Зөвлөх баг гүйцэтгэх ба энэ нь айл өрхийн хүсэл сонирхол болон төлбөрийн чадвар дээр суурилсан байна.

ТУН-ийн боловсруулсан урьдчилсан тохиролцооны хэлэлцээрийг Зөвлөх баг судлан үзэж шаардлагатай сайжруулалтыг хийнэ.

Урьдчилан тохиролцооны хэлэлцээр байгуулахын өмнө шаардлага хангасан гэж үзэн сонгогдсон айл өрхийн техникийн нөхцөлд үнэлгээ дүгнэлт өгөх ба үр дүнг ЭХЯ болон УБЦТС ТӨХК-тэй зөвшилцөж эцэслэнэ. (Айл өрхийн тоо нь цахилгаан түгээх дэд өртөөний хүчин чадлаас хамаарч хязгаарлагдах магадлалтай)

**Даалгавар 4: Мэдээлэл боловсруулалт ба тайлагналт**

Айл өрхийн дунд хийсэн тооллого, судалгааны үр дүнг цаасан хэлбэрээр бэлтгэн тайлагнана. Зөвлөх нь 8000 айл өрхөөс авсан мэдээллийг мэдээллийн санд үнэн зөв оруулна. Оруулсан мэдээллийг боловсруулах, хянах механизмыг бий болгоно. 8000 айл өрхөөс цуглуулсан техникийн болон нийгмийн өгөгдлүүдийг боловсруулж, үнэлнэ. Үнэлгээ дүгнэлт дээр үндэслэн эцсийн тайланг боловсруулж ирүүлнэ. Энэхүү эцсийн тайлан нь “дулаан хуримтлуурт” халаалтын хэрэгслийг ханган нийлүүлэх/суурилуулах гэрээт ажлын тендерийн баримт бичигт шаардлагатай бүтээгдэхүүний төрөл, хүчин чадал, техникийн тодорхойлолт, тоо хэмжээ гэх мэт бүх мэдээллийг агуулсан байна.

---

<sup>2</sup> Тухайн өрхийн цахилгааны хүчин чадал нь бкв бөгөөд 32А мөн эсэхийг шалгах (ampere breaker)

#### 4. Тайлагналт болон төслийн хуваарь

Зөвлөх багийн хүлээлгэн өгөх зүйлс:

- (1) Мэдээллийг SPSS (statistical analyses in social science) and STATA (software for statistics and data science) программуудыг ашиглан боловсруулах ба хувьсагч утгууд нь нэртэй, шошго таних тэмдэгтэй, статистик үр дүнтэй (бүх ангиллын хувьсагч утгуудын давтамж, хувьсагчдын статистик тодорхойлолт, өгөдлийн код гэх мэт) байна.
- (2) 8000 айл өрхийн техникийн маягт нь ажлын даалгавар 2-т дурдагдсан бүх мэдээллүүдийг багтаасан байна.
- (3) Ажлын даалгавар 4-т тусгасны дагуу айл тус бүрт хийсэн үнэлгээ, дүгнэлт, график, холболтын схем бүхий техникийн дэлгэрэнгүй тайлан боловсруулна
- (4) 8000 айл өрхтэй байгуулж гарын үсгээр баталгаажсан урьдчилсан тохиролцооны хэлэлцээр

Тайланг Англи Монгол хэл дээр бэлтгэн тус бүр 3 хувийг хүлээлгэж өгнө.

#### 5. Төлбөрийн хуваарь

Хүлээлгэн өгөх зүйл	Төлбөр
Эхлэлийн тайлан-Судалгааны асуулга, тооллого хийх маягт, дэд өртөөнүүдэд үнэлэлт өгсний үндсэн дээр айл өрхийг холболтоор нь группт хуваах болон гэрээт ажлыг гүйцэтгэх хүн хүчний хуваарилалт, арга аргачлал, төлөвлөгөө	20%
Явцын тайлан 1, Эхний 4000 айл өрхийн тооллого, судалгаа, боловсруулж бэлтгэсэн мэдээллийн баз, техникийн боломж, санхүүгийн чадавхид хийсэн үнэлгээ дүгнэлт, төсөлд хамрагдах боломжтой айл өрхийн мэлээлэл	25%
Явцын тайла 2, Дараагийн 4000 айл өрхийн тооллого, судалгаанд үндэслэн боловсруулсан мэдээллийн бааз, үнэлгээ дүгнэлт, эхний үр дүнгээс хамаарч олж авсан сургамж, өөрчилсөн арга барил, зөвлөмж	25%
Эцсийн тайлан-8000 айл өрхийн нэгдсэн мэдээлэл, урьдчилсан тохиролцооны хэлэлцээр	30%

#### 6. Үргэлжлэх хугацаа, ажиллах хүч

Зөвлөх үйлчилгээг 2019 оны 1-р сарын дундуур эхлүүлэх ба 8000 айл өрхөөс цуглуулж боловсруулсан мэдээлэл, урьдчилсан тохиролцооны хэлэлцээр бүхий эцсийн тайланг 2019 оны 4-р сарын 15-аас өмнө ТУН-д хүлээлгэж өгнө.

Зөвлөх үйлчилгээг ойролцоогоор 75 /далан тав/ хүн сар байх ба үүнээс багийн ахлагчийн ажиллах хүн сар 4 (дөрөв) байна. Үлдсэн хүн сарууд нь гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах дотоодын зөвлөхүүд, мэргэжилтнүүд болон айл өрхөөс ярилцлага хийж, мэдээлэл цуглуулах багийн бусад гишүүдэд ноогдоно.

## **7. Тавигдах шаардлага**

Багийн гишүүд холбогдох чиглэлээр өөрийн ур чадвар, мэдлэгийг харуулсан, хүлээн зөвшөөрөгдсөн туршлагатай байна.

Зөвлөх баг нь дараах шаардлагыг хангасан зөвлөхүүд, мэргэжилтнүүдтэй байх ба гэр хорооллын айл өрхүүдээр явж тооллого, судалгаа хийх чадвартай 20-оос доошгүй хүнийг багтаа багтаасан байна.

Багийн ахлагчид дараах шаардлага тавигдана. Үүнд:

- Цахилгаан/эрчим хүчний эсвэл холбогдох чиглэлээр мэргэжил эзэмшсэн, ижил төстэй туршилт судалгааны баг удирдаж байсан туршлагатай
- Гэр хорооллын цахилгаан хангамжийн систем, түгээх шугам сүлжээ, дэд өртөө/фидер болон айл өрхийн цахилгаан тэжээл / холболтын талаар мэдлэг туршлагатай
- Орон нутгийн онцлог, гэр хорооллын айл өрхийн сууцны нөхцөл байдал, дулаан алдагдал, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар мэдлэгтэй
- Цахилгаан эрчим хүчний үр ашгийн тооцоо, дүн шинжилгээнд суурилсан зөвлөмж өгөх чадвартай
- Англи Монгол хэл дээр техникийн дэлгэрэнгүй тайлан боловсруулах чадвартай
- Ижил төстэй салбарт ажилласан туршлага 10 жилээс багагүй байх

Зөвлөх багийн бүрэлдэхүүн нь дараах мэргэжилтнүүдээс бүрдсэн байх ба ижил төстэй салбарт ажиллаж байсан туршлага хамгийн багадаа 5 жил байна.

- Эрчим хүч/цахилгаан хангамжийн инженер мэргэжилтэй. Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн систем (нэгдсэн болон бие даасан)-ийн мэдлэгтэй, хэмжилт, гүйцэтгэлийн талаар туршлага хуримтлуулсан
- Дулаан хангамж, халаалт агаар сэлгэлтийн мэргэжилтэй, төрөл бүрийн халаалтын хэрэгсэл дээр ажиллаж байсан туршлагатай, тэдгээрийн гүйцэтгэлийг үнэлэх дадлага туршлагатай
- Барилгын хийц бүтээцийн инженер мэргэжилтэй, гэр хорооллын айл өрхийн сууцны талаар мэдлэгтэй, сууцны хийц бүтээцэд үнэлгээ өгөх чадвартай, эрчим хүчний үр ашгийн талаар дадлага туршлагатай
- Нийгмийн ажилтан эсвэл судалгааны мэргэжилтэн, ижил төрлийн судалгааны ажил хийж байсан туршлагатай, SPSS, STATA програм ашиглаж, мэдээлэл боловсруулах чадвартай

Зөвлөх баг нь зардал хэмнэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үүднээс 2 үүргийг 1 хүн гүйцэтгэж болно.

Ажлын даалгаврын хавсралт

Айл өрхийг сонгон шалгаруулах судалгаа

**А. Ерөнхий мэдээлэл**

УБЦТС ТӨХК-ийн хэрэглэгчийн дугаар (цахилгааны төлбөрийн хуудсан дээрх \_\_\_\_\_)

Нэг тоолуураас хэрэглэж байгаа өрхийн тоо \_\_\_\_\_

Өрх нь УБЦТС ТӨХК-өөс сар болгон цахилгааны төлбөрийн мэдээллийг авдаг эсэх (Тийм/Үгүй)

Өрхийн гишүүдийн тоо: Нийт; ..... Насанд хүрсэн эр ..... Насанд хүрсэн эм..... Хүүхэд .....

Өрхийн орлого: Ойролцоогоор: .....

Орлогын эх үүсвэр: А. Ажил эрхэлдэг гишүүн В. Тэтгэвэр С. Нийгмийн халамж

Ямар нэг санхүүгийн байгууллагаас авсан зээлтэй эсэх Тийм Үгүй

Өрхийн цахилгаан хэрэглээний сарын төлбөр /: .....

**В. Сууцны үзүүлэлт**

	Барилгын бүтцийн шинж чанар	Цахилгааны үндсэн хэрэглэгчээс дамжин хэрэглэгчийн тоо	Байшин сууц эзэмшигчийн төрөл/ нэгийг сонгоно/			
			Хувийн	Түрээс	Үнэгүй	Бусад
B1	Гэр		1	2	3	4
B2	Байшин сууц		1	2	3	4
B3	Бусад /...../		1	2	3	4

Өвлийн улиралд амьдарсан гэр-сууцны нөхцөл /өмнөх өвөл/

	ГЭр бол хэдэн ханатай	Хана	
B4a			
B4b	Гэрийн хананы дулаалгын материал, төрөл	Дан эсгий бүрээс ..... 1 Давхар эсгий бүрээс..... 2 Эсгий бус дулаалгын материал (цаас, даавуу г.м) ..... 3 Бусад/...../ ..... 4	
B4c	Гэрийн туурганы дулаалгын материал, төрөл	Дан эсгий туурга ..... 1 Давхар эсгийн туурга ..... 2 Эсгий бус туурга (цаас, даавуу г.м) ... 3 Бусад/...../ ..... 4	
B4d	Гэрийн шалны төрөл	Дан модон материал ..... 1 Давхар дулаалгын материал..... 2 Модон бус материал (картон цаас г.м) ..... 3	

		Бусад/...../.....4	
B4e	Гэрийн өрх	Эсгий өрх.....1 Эсгий бус материал (цаас, даавуу г.м) 2 Дулаалгагүй өрх.....3 Бусад/...../.....4	
B4f	Хүйтний улиралд танай байшин сууцанд гаднаас хүйтэн агаар орж ирдэг эсэх /нэгээс илүүг сонгож болно/	Цонх/тооно/.....1 Хана.....2 Шал.....3 Хаалга.....4 Гэрийн дээвэр.....5 Бусад /...../.....6	

Байшин сууцны шинж чанар үзүүлэлт /өмнөх жилийн өвлийн улирал/

B5a	Өрөөний тоо	Өрөөний тоо	
B5b	Шалны хэмжээ	м2	
B5c	Өнгөрсөн өвөл халаалт ашигласан өрөөний тоо	..... Халаалт ашигласан өрөөний тоо	
B5d	Өнгөрсөн өвөл халаалт ашигласан шал өрөөний хэмжээ	М <sup>2</sup> (халаасан)	
B5e	Байшин сууцны давхрын тоо	Давхар	
B5f	Хананы төрөл /нэгээс илүүг сонгож болно	Тоосго.....1 Бетон блок.....2 Балк /модон/.....3 Дүнз.....4 Нүхтэй блок.....5 Бусад/...../.....6	
B5g	Хана дулаалгатай эсэх	Бүх хана.....1 Зарим хана.....2 Дулаалгагүй.....3	
B5h	Хананы зузаан см	..... См	
B5j	Дээврийн материал /нэгээс илүүг сонгож болно	Нимгэн төмөр Хар цаасан Хавтан Шавар Шахмал хавтан Бусад/...../.....	
B5k	Дээврийн дулаалга	Тийм Тийм, хэсэгчилсэн Үгүй	
B5l	Тий бол дулаалгын төрөл /нэгээс илүүг сонгож болно	Үнс Үртэс Эсгий Цаас Хөөсөнцөр EPS Керамзит Бусад	
B5m	Шалны төрөл / нэгээс илүүг сонгож болно /	Мод Бетон Паркет	

		Асгамал хөрс, Хайрга Керамик/хавтан Хөөсөнцөр EPS Бусад/...../	
B5n	Хаалганы төрөл / нэгээс илүүг сонгож болно /	Дулаалгатай Дулаалгагүй Давхар модон хаалгатай Төмөр хаалга Бусад/...../	
B5o	Цонхны тоо	Цонхны тоо	
	Дан шилтэй цонхны тоо	Дан шилтэй цонхны тоо (Enter "0" for none)	
	Давхар шилтэй цонхны тоо	Давхар шилтэй цонхны тоо	
	3 Давхар шилтэй цонхны тоо	3 Давхар шилтэй цонхны тоо	
	Давхар цонхны тоо	Давхар цонхны тоо	
	Өвлийн улдиралд хананы халаагуур ашигладаг эсэх	Тийм..... 1 Үгүй ..... 2	
	Хүйтний улиралд танай байшин сууцанд гаднаас хүйтэн агаар орж ирдэг эсэх /нэгээс илүүг сонгож болно/	Цонх..... 1 Хана ..... 2 Шал Хаалга ..... 4 Бусад/...../ ..... 5	

**Хоол хийхдээ ямар зуух ашигладаг (Мөр бүрээр нь асуух)?**

	Зуухны төрөл	Өвөл				Зун			
		Байнга	Зарим даа	Хааяа	Хэрэг лэдэггүй	Байнга	Зарим даа	Хааяа	Хэрэглэ дэггүй
a	Уламжлалт зуух	1	2	3	4	1	2	3	4
b	Сайжруулсан зуух	1	2	3	4	1	2	3	4
c	Ханан пийшин	1	2	3	4	1	2	3	4
d	Усан халаалтын зуух /нам даралтын	1	2	3	4	1	2	3	4
e	Цахилгаан плитка	1	2	3	4	1	2	3	4
g	Газан плитка	1	2	3	4	1	2	3	4
f	Цахилгаан зуух	1	2	3	4	1	2	3	4
g	Будаа агшаагч	1	2	3	4	1	2	3	4
h	Цахилгаан ус буцалгагч	1	2	3	4	1	2	3	4
i	Бусад.....	1	2	3	4	1	2	3	4

**С. Нүүрсний хэрэглээ болон зарцуулалт**

Өмнөх жилд нүүрс ашигласан эсэх	Тийм ..... 1	
---------------------------------	--------------	--



		Үгүй..... 2	
	Ашигласан нүүрсний төрөл /нэгээс илүүг сонгож болно/	Түүхий ..... 1 Сайжруулсан ..... 2 Бусад..... 3	
	Нүүрс авсан арга /нэгээс илүүг сонгож болно/	Худалдаж..... 1 Өмнөх жилийн үлдэгдэл нүүрс ..... 2 Үнэгүй ..... 3 Бусад /...../..... 4	

Нүүрсний сарын хэрэглээ болон зарцуулалтын мэдээлэл

	1. Машины төрөл /ачааны портер г.м/ 2. Хэрэв үнэгүй бол 0 гэж бичих 3. Хэрэглэсэн нүүрсний хэмжээг тонн руу шилжүүлэхдээ дараах хүснэгтийг ашигла:			
	№	Төрөл	Хэмжих нэгж	Хэмжээ
	1	Портер	ton	1-2,5 тн
	2	Зил-130	ton	5 тн
	3	Жижиг шуудай	8-10kg-1 жижиг шуудай	100-125 жижиг шуудай=1тн
	4	ТОм шуудай	25kg- 1 Том шуудай	40 шуудай= 1тн

	Өмнөх жил Шуудайтай нүүрс худалдаж авсан эсэх			Тийм..... 1 Үгүй ..... 2			
	Худалдаж авсан:  1=Жижиг шуудай  2=Том шуудай	1кг	шуудайны тоо  /шуудайны тоо/	Нүүрс /кг/  /Хэдэн шуудайг хэрэглэсэн/	Үнэ 1 шуудай  /in төг/	Зарцуулсан төгрөг  /in Tg/	Ашигласан өдрийн тоо  /days/
1							

	Өрхийн гишүүдийн хэн нь ихэнхдээ нүүрсээ авдаг	Эрэгтэй гишүүн ..... 1 Эрэгтэй гишүүн ..... 2 Эр хүүхэд..... 3 Эм хүүхэд ..... 4 Бусад /...../..... 5	
--	--	---	--

**D. Эрчим хүчний хэмнэлттэй “дулаан хуримтлуурт” цахилгаан хэрэгсэл худалдаж авах сонирхолтой эсэх**

Төслөөс хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа эрчим хүчний хэмнэлттэй “дулаан хуримтлуурт” цахилгаан хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр худалдаж авах эсэх. Төлбөрийг 3 жилийн хугацаанд сард тогтмол төлж барагдуулна. 3 жилийн дараа бүтээгдэхүүнийг эзэмшинэ.

**Гэр**

Халаах талбай	ХАлаагуурын тоо	Халаагуурын хүчин чадал	Сарын төлбөр	Сарын цахилгааны төлбөр /өвөл/
25-30 м <sup>2</sup>	1	3.2 кВт	XXX төг/сар	Ххх төг/сар
30-45 м <sup>2</sup>	2	5-6.5 кВт	XXX төг/сар	Ххх төг/сар

Байшин сууцны хэмжээнээс хамаарч тухайн өрхөд шаардлагатай “дулаан хуримтлуурт” цахилгаан хэрэгслийн тоо хэмжээ, үнэ, сарын төлбөрийн хэмжээ тодорхойлогдоно. Та төлбөрийн тооцоолол хийж үзээд тус бүтээгдэхүүнийг авах эсэх	Тийм .....	1
	Үгүй.....	2
Цахилгаан хэрэгслийг аваад хуучин зуухаа хураалгах эсэх	Тийм .....	1
	Үгүй .....	2

**Байшин сууц**

Халаах талбай	Өрөөний тоо	ХАлаагуурын тоо	Халаагуурын хүчин чадал	Сарын төлбөр	Сарын цахилгааны төлбөр /өвөл/
<30 м <sup>2</sup>	1	1	3.5 kW	XXX төг/сар	Ххх төг/сар
30-50 м <sup>2</sup>	2	2-3	5-6.5kW	XXX төг/сар	Ххх төг/сар

<p>Байшин сууцны хэмжээнээс хамаарч тухайн өрхөд шаардлагатай “дулаан хуримтлуурт” цахилгаан хэрэгслийн тоо хэмжээ, үнэ, сарын төлбөрийн хэмжээ тодорхойлогдоно. Та төлбөрийн тооцоолол хийж үзээд тус бүтээгдэхүүнийг авах эсэх</p>	<p>Тийм ..... 1 Үгүй..... 2</p>	
<p>Цахилгаан хэрэгслийг аваад хуучин зуухаа хураалгах эсэх</p>	<p>Тийм ..... 1 Үгүй ..... 2</p>	